



# Санхүү, үйл ажиллагааны гүйцэтгэлийн ТОВЧ танилцуулга – 2024 оны 4-р улирал

---


Премиум Нэксус ХК  
MSE: CUMN

2025 оны 03-р сарын 06

1. 2024 оны онцлох үйл явдлууд
2. CU бизнесийн харьцуулсан болон нийт дэлгүүрийн гүйцэтгэл
3. CU бизнесийн стратегийн зорилтууд
4. Бусад охин компаниуд
5. Премиум Нэксус ХК нэгтгэсэн санхүү, үйл ажиллагааны тайлан
  - a) Орлого, үр дүнгийн голлох үзүүлэлт
  - b) Санхүүгийн байдлын тайлангийн гол үзүүлэлт
  - c) Мөнгөн гүйлгээний тайлангийн гол үзүүлэлт
6. Хувьцааны үнийн хөдөлгөөн




## Премиум Нэксус ХК



# CU Стратегийн зорилт


▲ Цэвэр борлуулалт /тэрбум төгрөг/

■ Дэлгүүрийн тоо



# CU Стратегийн зорилт (жилээр)

▲ Цэвэр борлуулалт /тэрбум төгрөг/



## Харьцуулсан дэлгүүрийн гүйцэтгэл

	2024 Q4
Өдрийн дундаж борлуулалтын өсөлт	25.2%
Өдрийн дундаж үйлчлүүлэгчдийн тооны өсөлт	9.6%
Сагсны үнийн өсөлт	14.2%


Харьцуулсан дэлгүүрийн тоо - 351

## Нийт дэлгүүрийн гүйцэтгэл

	2024 он
Өдрийн дундаж борлуулалтын өсөлт	21.9%
Өдрийн дундаж үйлчлүүлэгчдийн тооны өсөлт	6.6%
Сагсны үнийн өсөлт	14.3%

Нийт дэлгүүр дэлгүүрийн тоо: 374→ 445

2024 оны жилийн дундаж инфляц 6.8% байхад харьцуулсан дэлгүүрийн хэрэглэгчдийн сагсны хэмжээ дунджаар 14%-аар өссөн нь худалдан авагчдын сагсны хэмжээ бодит 7%-ын өсөлт үзүүлснийг харуулж байна.



## Гол онцлох үйл явдлууд

- 81 шинэ дэлгүүр нээж, 10-ыг хааж, нийт 445 дэлгүүртэй болсон.
- Улаанбаатар хотод 397, орон нутагт 50 дэлгүүр үйл ажиллагаа явуулж байна.
- 12 аймагт шинэ дэлгүүр нээж хүрээгээ тэлсэн.


Дэлгүүрийн тоо	2023	2024
CU	374	445

Борлуулалт (MNT)	2023	2024
CU	432 тэрбум	647 тэрбум



## Шимт цэс

Монголын уламжлалт хоолны орц болох таван цулыг ашиглан хийсэн витамин, эрдсээр баялаг эрүүл мэндэд тустай “ШИМТ ЦЭС” цуврал нь 5 цулын шөл, хуурга болон мантуун бууз гэсэн сонголтуудтай.



## Улирлын шинжтэй бүтээгдэхүүн

Улирлын онцлогт тохируулсан онцгой бүтээгдэхүүнүүдийг цаг тухай бүрд нь нэвтрүүлдэг. Жишээ нь хавар зуны улиралд борооны шүхэр, цув, гутлын углаа. Харин өвлийн намрын улиралд гар дулаацуулагч гэх мэт.



## Тэнцвэртэй хооллолтын меню

Эрүүл, тэнцвэртэй хооллолтыг эрхэмлэдэг хэрэглэгчдэд зориулсан хөнгөн боловч уураглаг Европ хоол болон салатыг амжилттай нэвтрүүлж хэрэглэгчдийн хүртээл болголоо.



## Шинээр нэвтэрсэн онцлох бүтээгдэхүүнүүд



### Хоолны шинэхэн бэлдэц HMR

Хүмүүсийн завгүй амьдралын хэв маяг тохирсон цаг хугацаа, ажиллагаа хэмнэх хоол хялбаршуулах хөлдөөсөн хоолны бэлдэц.



### Амтат шөл цуврал

Хүйтэн сэрүүний улиралд тохиромжтой шууд халаан хэрэглэх боломжтой "Амтат шөл" цуврал хоолнуудыг шинээр нэвтрүүлэв.



### Шорлосон тахиа

Хурдан бөгөөд амттай шинэхэн шарсан тахиа болон шарсан төмсүүдийг нэвтрүүлж хэрэглэгчдийн сонголтыг нэмэгдүүллээ.

"CU APP"-д шинээр нэвтэрсэн боломжууд.



**Credit card**

300,000₮ хүртэлх хүүгүй шимгэлгүй зээлийн үйлчилгээ



**CU Pay**

Ганцхан үйлдлээр төлбөр төлөлт, И-баримт, CU оноог цуглуулах шийдэл



**Loyalty market**

Өөрийн цуглуулсан оноогоороо худалдан авах боломжтой хямдрал



## “Үзүүлээд Өгье” аян

Насанд хүрээгүй хүүхдэд насны хязгаарлалттай бүтээгдэхүүн болох электрон болон утаат тамхи, согтууруулах ундаа худалдан авахаас урьдчилан сэргийлж иргэний бичиг баримтыг шалган худалдаалахад уриалсан “Үзүүлээд Өгье” аяныг хэрэгжүүлсэн.




## Соёл танаас эхлэнэ

Цагдаагийн Ерөнхий Газар болон GS25-тай хамтран "Соёл танаас эхэлнэ" аяныг амжилттай хэрэгжүүлсэн. Энэхүү аян нь нийтийн соёл ёс суртахууныг дээшлүүлж, илүү эелдэг, бусадтай илүү хүндэтгэлтэй харилцдаг сайхан нийгмийг бүтээхэд олон нийтийг уриалсан бөгөөд давхардсан тоогоор 65,278,300 хүнд хүрсэн томоохон аяны нэг болсон.



МОНГОЛ УЛСЫН ТӨП 100 АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЭРЭМБЭЭ АХИУЛАВ



"BEST TRAINING – СУРГАЛТ ХӨГЖЛИЙГ  
ДЭМЖИГЧ ШИЛДЭГ АЖИЛ ОЛГОГЧ"



## Сентрал Фүүдс ХХК

CU хоолны үйлдвэр нь нэгдсэн стандартын болон бүтээгдэхүүн үйлчилгээний баталгаажуулалтын тохирлын гэрчилгээг гардан авлаа

- MNS ISO 9001:2016,
- MNS ISO 22000:2019,
- MNS ISO 14001:2016,
- MNS CAC RCP 1:2023
- MNS 4946:2019

Нийт 5 стандартыг баталгаажуулсан анхны хоол үйлдвэрлэлийн байгууллага боллоо.



2024.7



## ҮЙЛ АЖИЛЛАГААГАА НЭГТГЭВ

2024.7-р сараас Централ Коммерс компани нь Чингис шар айргийн борлуулалт, түгээлт болон маркетингийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж эхэлсэн.

## ШИНЭ САВАЛГАА

Чингис шар айраг хэрэглэгчдэд хүртээмжтэй байдлаа нэмэгдүүлэх үүднээс 2 литрийн хэмжээтэй шинэ төрлийн савлагааг зах зээлд амжилттай нэвтрүүлэн CU салбаруудад борлуулж эхэлсэн.

## ЛОЯАЛТИ СИСТЕМ

Харилцагчийн лоялти системийн төслийг эхлүүлэн I-р үе шатыг амжилттай зохион байгуулан харилцагчдадаа урамшуулав.


## ON TRADE

Ногеса зах зээлд задгай шар айргаа тогтмол түгээсээр 2024 онд нийт 344 харилцагчидтай болж үйл ажиллагаагаа явуулж байна.



**Asahi Super Dry  
"Cherry blossom"**

Cherry blossom limited edition бүтээгдэхүүнээ зах зээлд танилцууллаа.



**Зах зээлийн тэлэлт**

Asahi Super Dry нь 2024 оны 5-р сараас эхлэн 21 аймагт албан ёсоор борлуулагдаж эхэллээ.



**Asahi Super Dry  
"Nama Jokki"**

2024 оны 11-р сараас эхлэн орчин үеийн шинэчлэл инновацыг өөртөө агуулсан лаазтай драфт шар айргийн төрлийг танилцууллаа.



**Asahi Super Dry  
Draught**

2024 оны 11-р сараас эхлэн Asahi Super Dry драфт шар айргийг зах зээлд нэвтрүүлээ.



### Ногоон үр

Шинэ ургацын чанартай ногоон кофены үрийг гарал үүслээс нь импортлон оруулж ирдэг.



### Герман технологи

Дэлхийн шилдэг Герман технологиор эх орондоо хуурч савлан кофегоо гаргаж байна.



### CU болон Ногеса

CU-гийн 445 салбар дэлгүүрүүдээр хэрэглэгчдэд хүргэхээс гадна Ногеса зах зээлрүү амжилттай нэвтэрч 86 харилцагчтай болсон.



### Кофены машин

Дэвшилтэт технологи бүхий Кофе машиныг шууд болон түрээсээр авах үйлчилгээг харилцагч нартаа санал болгож байна.





## ТҮГЭЭЛТИЙН ТӨВ

Хуурай түгээлтийн төв нь 550 дэлгүүрийн захиалгыг бэлтгэн гаргах чадалтай, нийт 6220мкв талбайд 140 ажилтантай үйл ажиллагаа явуулж байна.




## ХҮЙТЭН ХЭЛХЭЭ АГУУЛАХ

Хүйтэн хэлхээний агуулах нь 609 дэлгүүрийн захиалга бэлтгэн гаргах чадалтай, нийт 1000мкв талбайд 84 ажилтантай үйл ажиллагаа явуулж байна.



## ТЭЭВЭР, ТҮГЭЭЛТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Түгээлтийн төвүүдээс бэлтгэн гаргасан бараа бүтээгдэхүүнийг зориулалтын температурын дагуу тээвэрлэх тусгай нөхцөл, зориулалтын тоноглолтой, ISUZU брэндийн 70 автомашиныг худалдан авсан ба туслан гүйцэтгэгчийн 100 гаруй тээврийн хэрэгсэлийг энэхүү 70 машинаар орлох чадалтай байна.




## еBay

Америкийн томоохон онлайн худалдааны платформ болох еBay-г технологийн шийдлээр холбон тус платформ дээр борлуулагдаж буй 1,7 тэрбум гаруй бүхий л төрлийн бараа бүтээгдэхүүнээс авах боломжийг бий болгов. еBay-с хаанаас ч олохгүй эртний эдлэл, ховор сонин бараа, машины сэлбэг, технологийн бүтээгдэхүүн, төрөл бүрийн цуглуулга зэргийг авах боломжтой байдгаараа онцлог.




## JD.com (Жингдунг)

Fortune 500 компанийн 52-т жагсдаг Хятадын хамгийн том онлайн худалдаа, тээвэр, үл хөдлөх, инноваци судалгааны компани болон JingDong-той албан ёсны гэрээг үзэглэн JD.com дээр байршиж буй хүнс бус өргөн хэрэглээний барааг Монголын хэрэглэгчид Стора.мн-р дамжуулан авах боломжтой болов. Уг хамтралын хүрээнд хоёр платформ хоорондоо холбогдоод зогсохгүй JingDong Logistic-той хамтран Хятадын өнцөг булан бүрээс Монгол улс руу тээвэрлэх тээврийн гэрээг мөн байгууллаа.



## Stora V2.0

Үүсгэн байгуулагдсаны 3 жилийн ойгоо угтан Стора Централ ХХК нь системийн бүрэн шинэчлэлтээ хийн V2.0 хувилбараа танилцуулан асаав. Уг шинэчлэсэн хувилбар нь хэрэглэгчид илүү ойлгомжтой дизайн, процесс болон хэрэглэгчдийн эрэлт хүсэлтэд нийцсэн цоо шинэ 6 дэлгүүрийг холбон танилцуулсанаараа онцлог юм. Уг хувилбарт Ikea, Apple, Costco, Sephora, Nike, Victoria Secret багтсан бөгөөд Монголын хэрэглэгчдэд уг брендүүдийн бүтээгдэхүүнийг ямар нэг далд ашиг шингээгүй үнээр худалдан авах боломжийг нээв



## StoreForGood – Байгалд хайртай сонголт

Стора Централ ХХК нь Тогтвортой хөгжлийн 17 зорилгын хүрээнд StoreForGood хэмээх төслийг санаачлан хэрэгжүүлж эхлэв. Уг төсөл нь хүмүүсийн хамгийн дутуу хэрэглэн хаядаг, хэрэгцээгүй худалдан авалт их хийдэг, үйлдвэрлэх нөөц болон байгальд шингэх хор хөнөөл ихтэй бүтээгдэхүүнийг хоорондоо солилцон хэрэглэх замаар насыг нь уртасгаж хог хаягдлыг багасгах зорилготой юм.

Уг төслөөр дамжуулан стора.мн болон сторабоксын дэд бүтцийг ашиглан хүмүүс хоорондоо:

1. Ном
2. Хүүхдийн тоглоом
3. Хувцас солилцох боломжийг олгож байна. Цаашид солилцох бүтээгдэхүүний хүрээг илүү нэмэгдүүлж байгалд ээлтэй сонголт хийн өөрийн хэрэглэхээ больсон эд хэрэглэлээ хоорондоо солилцох шинэ үеийн трендийг бий болгон хөгжүүлэхээр төлөвлөж байна

## Байгууллагын хангамжийн аутсорсинг үйлчилгээ

Албан байгууллагуудад хамгийн ихээр тулгамддаг төрөл бүрийн худалдан авалт, үнэ харьцуулалт, судалгааны ажлыг хөнгөвчлөн Байгууллагын харилцагчидадаа зориулан цогц худалдан авалтын үйлчилгээг зах зээлд танилцуулав. Уг үйлчилгээгээр дамжуулан албан байгууллагууд Америк болон Хятадаас хүссэн тоног төхөөрөмж, мерч бүтээгдэхүүн, тусгай хэрэгцээт бараа, оффис тавилга, электрон бараа, бичиг хэргийн бүтээгдэхүүн, бэлэн дурсгалын зүйлс гээд бүхий л төрлийн бүтээгдэхүүнийг илүү хямд, илүү сонголттой захиалах боломжийг олгож байгаа юм.

Уг үйлчилгээ нь захиалга, тээвэрлэлт, гаалийн бүрдүүлэлт, судалгаа, зөвлөгөө, үнийн харьцуулалт гээд цогц шийдлийг багтаасан.

(Сая төгрөгөөр)	2022	2023	2024
Нийт цэвэр борлуулалт	261,018.9	390,496.6	598,378.7
Борлуулалтын өртөг	248,057.7	367,483.9	487,852.9
Нийт ашиг (алдагдал)	12,961.2	23,012.7	110,525.7
<i>Нийт ашгийн хувь</i>	5.0%	5.9%	18.5%
Үйл ажиллагааны зардал	9,395.0	13,234.6	28,352.1
<b>ХТЭХӨАшиг</b>	<b>3,566.2</b>	<b>9,778.1</b>	<b>82,173.7</b>
<i>ХТЭХӨАшгийн хувь</i>	1.4%	2.5%	13.7%
Элэгдэл Хорогдол	18,021.4	27,436.1	32,898.4
Мөнгөн бус зүйлс	(489.5)	1,832.3	21,263.2
ХТӨАшиг	(14,944.7)	(15,825.7)	70,538.5
Санхүүжилтийн зардал	11,146.9	17,506.5	19,062.9
Татварын өмнөх ашиг	(26,091.6)	(33,332.2)	51,475.7
Татварын зардал	(407.2)	(625.9)	3,062.3
<b>Цэвэр ашиг/алдагдал</b>	<b>(25,684.4)</b>	<b>(32,706.3)</b>	<b>48,413.4</b>
<i>Цэвэр ашгийн хувь</i>	-9.8%	-8.4%	8.1%

**IFRS 3** нь **бизнесийн нэгдлийг худалдан авалтын аргаар** бүртгэхийг шаарддаг стандарт юм. Энэ нь худалдан авагчийг тодорхойлох, хөрөнгө, өр төлбөрийг зах зээлийн бодит үнээр үнэлэх, гудвилл эсвэл ашигтай худалдан авалтыг бүртгэх зэрэг үндсэн зарчмуудыг агуулдаг.

## Goodwill or Bargain purchase

- $\text{CONSIDERATION PAID} > \text{FAIR MARKET VALUE} \Rightarrow \text{GOODWILL}$
- $\text{CONSIDERATION PAID} < \text{FAIR MARKET VALUE} \Rightarrow \text{GAIN ON BARGAIN PURCHASE}$

Нийт хөрөнгө болон өр төлбөрийг худалдан авалтын өдрийн зах зээлийн бодит үнээр бүртгэнэ.

Multi-Period Excess Earnings Method (MPEEM) аргаар **брэндийн өнөөгийн үнэ цэнийг** тооцно.

Энэхүү үнэлгээний тайланг хөндлөнгийн үнэлгээний байгууллага болох MBVC Asset Valuation ХХК гүйцэтгэж KPMG ХХК хянаж баталгаажуулсан болно.


<b>Net asset value</b>	<b>Book value at acquisition date</b>	<b>Fair value at acquisition date</b>
Property, plant and equipment	5,782,145,426	17,939,506,858
Intangible asset (trade name)	-	32,219,617,785
Current assets and other non-current assets	3,834,090,984	3,834,090,984
Current liabilities	(3,637,764,421)	(3,637,764,421)
<b>Net asset value</b>	<b>5,978,471,989</b>	<b>50,355,451,207</b>
Consideration		21,510,000,000
Non-controlling interest		5,035,545,121
<b>Consideration + NCI</b>		<b>26,545,545,121</b>
Deferred tax on fair value increase		4,333,249,162
<b>Gain on bargain purchase</b>		<b>19,476,656,924</b>

(Сая төгрөгөөр)	2022	2023	2024
<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>44,439.9</b>	<b>40,170.3</b>	<b>81,007.3</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	4,280.7	2,980.6	10,431.5
Дансны авлага	432.7	641.3	6,042.3
Бараа материал	31,838.4	28,250.0	47,194.5
Бусад эргэлтийн хөрөнгө	7,888.1	8,298.4	17,339.0
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>126,608.8</b>	<b>153,324.6</b>	<b>233,085.1</b>
Биет болон биет бус хөрөнгө	73,189.7	90,193.8	157,907.5
Ашиглах эрхтэй хөрөнгө	46,963.4	50,534.8	60,568.6
Бусад эргэлтийн бус хөрөнгө	6,455.6	12,595.9	14,608.9
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>	<b>171,048.7</b>	<b>193,494.9</b>	<b>314,092.4</b>
<b>Богино хугацаат өр төлбөр</b>	<b>73,761.6</b>	<b>116,172.9</b>	<b>116,553.0</b>
Дансны өглөг	40,714.3	42,916.4	57,119.4
Богино хугацаат зээл	17,290.8	19,969.9	25,360.3
Бусад богино хугацаат өр төлбөр	15,756.5	53,286.5	34,073.3
<b>Урт хугацаат өр төлбөр</b>	<b>78,849.4</b>	<b>91,590.7</b>	<b>93,739.7</b>
Урт хугацаат зээл	28,197.7	33,999.8	23,911.7
Бусад урт хугацаат өр төлбөр	50,651.7	57,590.9	69,828.0
<b>Эздийн өмч</b>	<b>18,437.6</b>	<b>(14,268.7)</b>	<b>103,799.7</b>
Энгийн хувьцаа	81,776.9	81,776.9	111,425.2
Нэмж төлөгдсөн капитал	13,820.5	13,820.5	45,757.9
Эздийн өмчийн бусад хэсэг	318.7	318.7	8,388.0
Хуримтлагдсан ашиг	(77,478.5)	(110,184.8)	(61,771.4)
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>171,048.7</b>	<b>193,494.9</b>	<b>314,092.4</b>

(Сая төгрөгөөр)	2022	2023	2024
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлогын дүн (+)	291,091.9	429,705.3	698,620.5
Мөнгөн зарлагын дүн (-)	(299,491.7)	(427,286.4)	(637,707.0)
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(8,399.8)</b>	<b>2,418.9</b>	<b>60,913.5</b>
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлогын дүн (+)	17,170.6	109.2	3,152.3
Мөнгөн зарлагын дүн (-)	(30,915.5)	(33,646.3)	(40,723.4)
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(13,744.9)</b>	<b>(33,537.1)</b>	<b>(37,571.1)</b>
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлогын дүн (+)	42,842.0	33,906.6	70,712.9
Мөнгөн зарлагын дүн (-)	(20,204.2)	(31,903.1)	(86,473.0)
Хоорондын тооцоо (+/-)	-	27,920.7	-
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>22,637.8</b>	<b>29,924.2</b>	<b>(15,760.1)</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн гадаад валютын ханшийн зөрүү	(273.6)	(106.0)	(131.2)
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>219.6</b>	<b>(1,300.1)</b>	<b>7,450.9</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,061.2	4,280.7	2,980.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,280.7	2,980.6	10,431.5



Indexed performance





Үнэт цаасны танилцуулга

## 3.6 Санхүүгийн төсөөлөл

### Орлогын тайлангийн төсөөлөл

Хүснэгт 19. Орлого, үр дүнгийн хураангуй тайлан, тэрбум төгрөгөөр

Орлогын тайлан	2021T	2022T	2023T	2024T	2025T	2026T	2027T	2028T	2029T	2030T
Борлуулалтын орлого	88.5	237.9	390.1	475.4	518.0	561.4	595.1	630.8	668.7	708.8
Борлуулалтын өртөг	(94.8)	(229.8)	(356.9)	(424.1)	(449.6)	(475.7)	(502.8)	(531.1)	(559.6)	(590.8)
Нийт ашиг, алдагдал	(6.2)	8.0	33.2	51.3	68.3	85.7	92.3	99.8	109.0	118.0
Ерөнхий ба удирдлагын зардал	(6.8)	(9.8)	(11.0)	(11.4)	(11.8)	(12.2)	(12.5)	(13.0)	(13.5)	(14.1)
Үйл ажиллагааны ашиг, алдагдал	(13.1)	(1.7)	22.2	39.9	56.5	73.5	79.8	86.8	95.5	103.9
Цэвэр санхүүгийн зардал	(1.8)	(1.5)	(1.1)	(0.7)	(0.3)	(0.2)	(0.1)	(0.0)	-	-
Түрээсийн хүүгийн зардал	(5.2)	(8.7)	(11.6)	(13.6)	(12.6)	(11.5)	(11.7)	(10.1)	(8.2)	(7.7)
Татварын өмнөх ашиг, алдагдал	(20.1)	(12.0)	9.5	25.6	43.6	61.8	68.0	76.7	87.3	96.2
Орлогын албан татварын хөнгөлөлт, (зардал)	(0.0)	-	(0.7)	(2.6)	(7.9)	(14.2)	(15.6)	(17.3)	(19.1)	(20.7)
Татварын дараах ашиг, алдагдал	(20.1)	(12.0)	8.8	23.0	35.7	47.6	52.4	59.4	68.2	75.6

Эх сурвалж: СТОУС-ын дагуух Үнэт цаас гаргагчийн санхүүгийн төсөөлөл

(Сая төгрөгөөр)	2022	2023	2024
Нийт цэвэр борлуулалт	261,018.9	390,496.6	598,378.7
Борлуулалтын өртөг	248,057.7	367,483.9	487,852.9
Нийт ашиг (алдагдал)	12,961.2	23,012.7	110,525.7
Нийт ашгийн хувь	5.0%	5.9%	18.5%
Үйл ажиллагааны зардал	9,395.0	13,234.6	28,352.1
<b>ХТЭХӨАшиг</b>	<b>3,566.2</b>	<b>9,778.1</b>	<b>82,173.7</b>
ХТЭХӨАшгийн хувь	1.4%	2.5%	13.7%
Элэгдэл Хорогдол	18,021.4	27,436.1	32,898.4
Мөнгөн бус зүйлс	(489.5)	1,832.3	21,263.2
ХТӨАшиг	(14,944.7)	(15,825.7)	70,538.5
Санхүүжилтийн зардал	11,146.9	17,506.5	19,062.9
Татварын өмнөх ашиг	(26,091.6)	(33,332.2)	51,475.7
Татварын зардал	(407.2)	(625.9)	3,062.3
<b>Цэвэр ашиг/алдагдал</b>	<b>(25,684.4)</b>	<b>(32,706.3)</b>	<b>48,413.4</b>
Цэвэр ашгийн хувь	-9.8%	-8.4%	8.1%

## 47 дугаар зүйл. Ногдол ашиг хуваарилах нөхцөл

47.1. Компани нь дор дурдсан тохиолдолд энгийн хувьцаанд ногдол ашиг хуваарилна:

47.1.1 Ногдол ашиг төлсний дараа компани нь төлбөрийн чадвартай байх;

47.1.2 Ногдол ашиг төлсний дараа компанийн **өөрийн хөрөнгийн хэмжээ** нь энэ хуулийн 30.5-д заасан **хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ**, давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, түүний татан буулгалтын үнэ зэргийн нийлбэрээс их байх;

47.1.3 Компани нь эргүүлэн худалдаж авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх.

47.2 Компани эргүүлэн худалдаж авсан өөрийн хувьцаанд ногдол ашиг хуваарилахгүй.

47.3 Компани нь дараах нөхцөлд давуу эрхийн хувьцаанд ногдол ашиг хуваарилна:

47.3.1 Ногдол ашиг төлсний дараа компани нь төлбөрийн чадвартай байх;

47.3.2. компани нь эргүүлэн худалдаж авах үүрэгтэй давуу эрхийн хувьцааг бүрэн авсан байх.

47.4. Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь 25-аас дээш хувиар багассан тохиолдолд компани нь ногдол ашгийг шилжүүлсэн өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор зээлдүүлэгчид өөрийн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээр, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэнэ.



Анхаарал  
хандуулсанд  
баярлалаа

Холбоо барих бол:  
IR manager Ц. Номуундалай  
И-мэйл: [investor@cumongol.mn](mailto:investor@cumongol.mn)